



УЛААНБААТАР СПОРТ МЕНЕЖМЕНТ ХК
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Дотоод хяналт шалгалтын
журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 35 дугаар зүйл, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар спорт менежмент” ХК-ийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг нэгдүгээр, дотоод хяналт шалгалт зохион байгуулах бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмыг нийт ажилтанд танилцуулж ажиллахыг Үйл ажиллагаа, зохион байгуулалтын албаны дарга (Г.Сүнжидмаа)-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Ерөнхий менежер (Б.Ууганбаатар)-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.ХУЛАН

1725020042